



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 4/153

Мандалговь

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3, “а” “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэх журмыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Тэвш багийн нутаг “Бага булаг” /N46.06.05.2/ /E105.58.55.5/ гэх газарт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн 14 хоногт малын өвчлөл илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан ч малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ард иргэд, малчдыг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Е.Отгонцэцэг), тархвар зүйч эмч (Д.Эрдэнэцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

